

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- ☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 222,
2021 оны 378 дугаар тогтоол

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан
огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт
зохицуулалтын газар

Чанарын хяналтын газар

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Эм биобэлдмэлийн хяналтын улсын ахлах
байцаагч

Дэс түшмэл, ТЗ-8

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдөр 8 цаг

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр
хороо, UBH center, 8, 11 дүгээр давхар

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Нийслэл, орон нутгийн хэмжээнд эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлын талаарх хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан хяналт шалгалт хийх, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актын биелэлтэд хяналт тавьж, болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, улсын ахлах байцаагчийн үйл ажиллагаа, хяналт шалгалтыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд явуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.


Албан тушаалын зорилт:

1. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлын талаарх хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх;
2. Эм, эмнэлгийн хэрэгслийн талаарх хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, салбарын хяналтын бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийг зохион байгуулах, гүйцэтгэлийг тайлагнах;
3. Улсын байцаагчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэх;
4. Улсын байцаагчийн шийдвэрийг шүүхээр баталгаажуулан албадан гүйцэтгүүлэх, эсхүл тухайн үйлдвэрлэл, үйлчилгээг бүрмөсөн зогсоох тухай санал, дүгнэлтээ холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;
5. Улсын байцаагчийн үйл ажиллагаа болон хяналт шалгалттай холбогдуулан гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх;
6. Холбогдох хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.


Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Гүйцэтгэх-Г Хянах - Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Эм хангамжийн болон эрүүл мэндийн байгууллагуудад эм зүйн чиглэлээр хийх хяналтын бодлогыг боловсруулан хэрэгжүүлж, зохион байгуулах;	Хяналтын бодлого боловсронгуй болж, хэрэгжилт хангагдана.	Г
	2.Хяналт шалгалтын үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, удирдлага арга зүйгээр хангах;	Хяналт шалгалтын ажлыг оновчтой төлөвлөн, хэрэгжүүлж, үр дүн дээшилсэн байна.	Г, Х
	3.Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдалд тавих хяналтын бодлогыг хэрэгжүүлэх, хийсэн хяналт шалгалтын үйл ажиллагаа түүний гүйцэтгэлд үнэлэлт дүгнэлт өгөх;	Хууль, тогтоомжийн хэрэгжилт сайжирна.	Г, Х
	4. Хяналт шалгалтын дүнд тулгуурлан эрх зүйн орчныг боловсронгуй болгох саналыг зохих газарт хүргүүлэх, холбогдох журам, зааврын төслийг боловсруулах;	Хяналт шалгалт хийх эрх зүйн орчин боловсронгуй болсон байна.	Г, Х
	5.Салбарын хэмжээнд хэрэгжүүлэх, хийх арга хэмжээний саналыг боловсруулах, зохих газарт тавьж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;	Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна.	Г, Х
	6.Эм, биобэлдмэлийн хяналтын чиглэлээр эрсдэлийн шалгуур үзүүлэлт боловсруулах, боловсронгуй болгох санал өгөх;	Эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх нөхцөл бүрдэнэ.	Г, Х



	7.Хяналт шалгалтын объектын эрсдэлийн үнэлгээг хийж, нэгдсэн санг бүрдүүлэх, мэдээлэлд дүн шинжилгээ хийх;	Хяналт шалгалтын төлөвлөлтийг хийх боломж бүрдэнэ.	Г, Х
	8.Хяналт шалгалтад ашиглах хяналтын хуудас болон хяналтын хуудсыг ашиглах зөвлөмжийг шинээр болон шинэчлэн боловсруулах, арга зүйгээр хангах, санал өгөх.	Хяналт шалгалтыг нэг чиглэлээр хийх нөхцөл бүрдэнэ.	Г, Х
2 дугаар зорилтын хүрээнд	1.Улсын байцаагчийн бүрэн эрхийн хүрээнд хууль тогтоомжийн дагуу хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэх, тайлагнах;	Хяналт шалгалтыг хууль тогтоомжийн хүрээнд хийсэн байна.	Г, Х
	2.Эм, биобэлдмэлийн хяналтын чиглэлээр хийсэн хяналт шалгалтын дүнг нэгтгэн цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмжийг боловсруулж хэлэлцүүлэх, шалгалтын дүнг холбогдох газарт хүргүүлэх;	Хууль тогтоомжийн хэрэгжилт сайжирсан байна.	Г, Х
	3.Цаг үеийн шаардлагатай уялдуулан нийтийг эрсдэлээс хамгаалах хяналт шалгалтыг зохион байгуулах ажлыг удирдах, хэрэгжүүлэх;	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдана	Г, Х
	4.Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу хийж, гүйцэтгэх;	Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулсан байна.	Г, Х
	5.Хяналтын чиглэлээр эрүүл мэндийн байгууллага болон эм хангамжийн байгууллагуудын мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулах зөвлөмж, гарын авлагаар хангаж, үр дүнг тооцох;	Хууль эрх зүйн мэдлэг дээшилсэн байна.	Г, Х
	6.Байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг мэдээлэл, зөвлөмжөөр хангах, хяналт шалгалтын үйл ажиллагааг хуулийн хүрээнд олон нийтэд сурталчлах;	Мэдээлэл, зөвлөмжөөр хангагдсан байна.	Г, Х
	7.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг акт үйлдэж улсын орлого болгох, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх;	Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна.	Г, Х
	8.Улсын байцаагчийн шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд шийдвэрийг шүүхээр баталгаажуулан албадан гүйцэтгүүлэх, эсхүл тухайн үйлдвэрлэл, үйлчилгээг бүрмөсөн зогсоох тухай санал,	Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна.	Г, Х



	дүгнэлтээ холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;		
	9.Ноцтой осол аюул гарсан, хүний амь нас, эрүүл мэнд хохирсон, их хэмжээний хор хохирол учирсан тохиолдолд болон илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй бол шалгалтын акт, холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.	Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна.	Г, Х
3 дугаар зорилтын хүрээнд	1.Улсын байцаагчдын хяналт шалгалтын баримт бичиг, албан бичгийг хянах, зохих стандартыг мөрдүүлэх, хяналт шалгалтын үйл ажиллагаа, түүний гүйцэтгэлд үнэлэлт, дүгнэлт өгөх;	Мэргэжил арга зүйгээр хангагдана	Г, Х
	2.Улсын байцаагчдыг мэргэжил арга зүйгээр хангаж, хууль, тогтоомжийг танилцуулан, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах;	Улсын байцаагчдын мэдлэг дээшилнэ.	Г, Х
	3.Төв, орон нутгийн улсын (ахлах) байцаагчдын мэдлэг, ур чадварын түвшин, сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, түүнд тулгуурлан саналаа танилцуулах;	Сургалтын хэрэгцээ шаардлага зөв тодорхойлогдсон байна.	Г, Х
	4.Улсын байцаагчдыг мэргэшүүлэх, давтан сургах сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах.	Мэдлэг, ур чадвар сайжирна.	Г, Х
4 дугаар зорилтын хүрээнд	1.Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийг шүүхээр баталгаажуулан албадан гүйцэтгүүлэх, эсхүл тухайн үйлдвэрлэл, үйлчилгээг бүрмөсөн зогсоох тухай санал, дүгнэлтээ холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;	Хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн байна.	Г, Х
	2.Хууль тогтоомжоор өөрт олгогдсон эрх, үүргийг хэрэгжүүлэх, авлигаас ангид, хүнд сурталгүй, гаднын нөлөөнөөс ангид ажиллах;	Үйл ажиллагаа хууль тогтоомжийн хүрээнд явагдах нөхцөл бүрдэнэ.	Г
	3.Байгууллагын дотоодод мөрдөгдөж буй дүрэм, журмын хэрэгжилтийг хангах, холбогдох хууль, тогтоомжийн дагуу нэгжийн менежертэй гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулах, тайлагнах, үр дүнг дүгнүүлэх;	Хуулийн хугацаанд тайлагнаж, дүгнүүлсэн байна.	Г
	4.Чанарын хяналтын газрын дотоод ажил үүргийн хуваарийн дагуу удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлж ажиллах.	Дотоод чиг үүргийн хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х




5 дугаар зорилтын хүрээнд	1.Улсын байцаагчийн үйл ажиллагаа болон хяналт шалгалттай холбогдуулан гаргасан гомдлыг хянах, зохих шийдвэрийг гаргах, шаардлагатай тохиолдолд асуудлыг магадлах зорилгоор лабораторийн буюу магадлан шинжилгээг холбогдох байгууллагаар хийлгүүлэх, шийдвэрлэх;	Хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн байна.	Г, Х
	2.Улсын байцаагч хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулахдаа холбогдох хууль, эрх зүйн баримт бичиг болон улсын байцаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөн ажиллаж байгаад хяналт тавих.	Хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн байна.	Г, Х
6 дугаар зорилтын хүрээнд	1.Архив, албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартын дагуу баримт бичгийг боловсруулах, архивын нэгж бүрдүүлж ажиллах;	Хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн байна.	Г, Х
	2.Төрийн албаны тухай хууль болон төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох, чанд сахиж ажиллах;	Ёс зүйн зөрчилгүй ажилласан байна.	Г
	3.Авлигын эсрэг болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг судлан хэрэгжүүлж, ашиг сонирхлын зөрчил гаргахаас сэргийлэн ажиллах.	Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах нөхцөл бүрдэнэ.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.		
Мэргэжил	Эм зүй /091601/.		
Мэргэшил	- төрийн албаны мэргэшүүлэх зохих багц сургалтад хамрагдсан байх - эм зүйн чиглэлээр мэргэшүүлэх сургалтуудад хамрагдсан байвал давуу тал болно.		
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- албан хаагчийн санал, бодлыг нь сонсох, эргэх холбоотой байх, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - улсын байцаагчдын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг сайжруулахад зөвлөх, чиглүүлэх; - үйл ажиллагааны явцад үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах; - хяналтын цахим систем дахь хяналт шалгалтын мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах; - хяналтын объектуудын эрсдэлийн үнэлгээний дүнд шинжилгээ хийх, харьцуулсан судалгаа гаргах; - нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодорхойлох, хийх.	

		- хийгдсэн хяналт шалгалтын дүнд шинжилгээ хийх, харьцуулсан судалгаа гаргах; - бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийж, үндэслэлтэй санал боловсруулах; - шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх; - хариуцсан ажлын чиглэлээр судалгаа шинжилгээ хийх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	- хуульд нийцсэн оновчтой, үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах; - тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, хувилбарыг боловсруулж удирдлагад танилцуулах; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн, ашиг сонирхлоос ангид, оновчтой, шуурхай, үр дүнтэй шийдвэр гаргах; - мэдээллийн нууцлал, аюулгүй байдлын хэм хэмжээ баримталдаг байх; - хяналт шалгалтыг хэрэгжүүлэх арга замыг оновчтой тодорхойлж, шийдвэрийн төсөлд тусгах; - гаргасан шийдвэрийнхээ үр дүнг хариуцах; - бусад.
	Багаар ажиллах	- ёс зүйгээр хамт олноо манлайлан үлгэр дуурайлал үзүүлэх; - өөрийн мэдлэг, мэдээллээ хамт олонтой хуваалцах, түгээн дэлгэрүүлэх; - төрийн албан хаагчийн ёс зүйг чанд сахих; - төрийн болон хувь хүний нууцыг хадгалах; - бусадтай хүндэтгэлтэй, адил тэгш, итгэл төрүүлэхүйц, ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - бусдын санал бодлыг анхааралтай сонсож санал санаачилгыг дэмждэг байх; - аливаа асуудлыг хамтын ажиллагаанд тулгуурлан шийдвэрлэдэг байх; - аливаа сөргөлдөөн, зөрчилдөөнийг эвээр зохицуулах; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтын хувьд хамт олныг манлайлах; - бусад.
	Бусад	- олон нийттэй харилцах; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; - мэдээллийн технологийн дэвшилтэт арга технологийг ашиглах; - цахим харилцааг ашиглах мэдээлэл солилцох, мэдээллийг шуурхай хүргэх; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч нээлттэй харилцааг бий болгох, багаар ажиллах; - мэдлэг, мэргэжлээ тогтмол дээшлүүлэх, шинэ санаачилга гаргаж ажиллах; - кирилл болон үндэсний бичгээр албан бичиг хөтлөх чадвартай байх; - бусад.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ



Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
Чанарын хяналтын газрын дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах
албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект:


- Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын дарга, нэгжийн дарга нар, мэргэжилтнүүд, Эм шинжлэх лабораторийн менежер, шинжээч нар
- Яам, агентлаг, төрийн болон төрийн бус байгууллага, ажлын алба, албан хаагчид
- Хяналт шалгалтад хамрагдах байгууллага, аж ахуйн нэгж, иргэн

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолт
боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж,
батлах зөвшөөрөл олгосон байгууллагын
шийдвэр:

Албан тушаал:
Чанарын хяналтын газрын дарга


.....Г.Номин

Байгууллагын нэр:
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: **22 12 14**

Дугаар: **635**

20... оны ... сарын ... -ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:


Байгууллагын нэр:

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

Шийдвэрийн огноо: **2023. 01. 09.**

Дугаар: **A/06.**

(тамга/тэмдэг)

ДАРГА.....  Д.НАРАНТУЯА

20 **23** оны **01** дугаар сарын **09** -ны өдөр

